

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 23-ны өдөр

№ 20/35

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх зарим хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн Үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Компанийн ТУЗ-ийн 2020 оны 12 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:

а. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Эрсдлийн удирдлагын хороо:

Хорооны дарга: Б.Дэлгэржаргал;
Гишүүд: С.Энх-Амгалан;
О.Болдбаатар;
Н.Цэвэгмид;
В.Баярсайхан;
Б.Өлзийбаяр.

б. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хороо:

Хорооны дарга: С.Энх-Амгалан;
Гишүүд: С.Боргил;
Б.Өлзийбаяр.

2. Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, холбогдох бусад баримт бичгийг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршсан мэдээлэлд өөрчлөлт оруулах, Санхүүгийн Зохицуулах хороо болон олон нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар), ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг) нарт үүрэг болгосугай.



ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 23-ны өдөр

№ 20/36

Улаанбаатар хот

Чанаргүй болон муу активыг Зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 144/125 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6.4 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 12 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Гүйцэтгэх захирлын саналыг үндэслэн 373,492,516 (*гурван зуун далан гурван сая дөрвөн зуун ерэн хоёр мянга таван зуун арван зургаа*) төгрөгтэй тэнцэх чанаргүй болон муу активыг, тэдгээрт тооцогдох 17,380,794 (*арван долоон сая гурван зуун наян мянга долоон зуун ерэн дөрөв*) төгрөгтэй тэнцэх зээлийн шимтгэлийг сангаас хорогдуулах, ийнхүү хорогдуулсантай холбогдох нягтлан бодох бүртгэлийн гүйлгээг 2020 оны 12 сарын 31-ний өдөрт багтаан хийх эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д олгосугай.
2. Компанийн Зээлийн эрсдэлийн сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааг холбогдох хууль, тогтоомж болон Санхүүгийн тайлагналын Олон улсын стандартын шаардлагуудад нийцүүлэн хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.



ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 23-ны өдөр

№ 20/37

Улаанбаатар хот

Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2, 49.4 болон 49.5 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.15 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.2, 22.4 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 12 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн нийт гаргасан хувьцааны 5 (тав) хувиас хэтрэхгүй хэмжээний хувьцааг энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасан нөхцөлийн дагуу Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдан авч, халааслахаар шийдвэрлэсүгэй.
2. “ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслах журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралт 2-оор баталсугай.
3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, Төлөөлөн Удирдах Зөвлөлийг холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д үүрэг болгосугай.





“ЛэндМН ББСБ” ХК-ийн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн
ээлжит хурлын 20/37 тоот тогтоодын Хавсралт 1

КОМПАНИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВЧ ХАЛААСЛАХ НӨХЦӨЛ	
1. Нэг өдөрт эргүүлэн худалдаж авах хувьцааны тооны дээд хязгаар	Төлөөлөн удирдах зөвлөлийн эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсөн нийт энгийн хувьцааны 10 (арав) хувиас хэтрэхгүй. Энэ журам нь доорх 4 дэх хэсэгт заасан Багц худалдан авалтад хамаарахгүй.
2. Дараалсан 30 хоногийн хугацаанд эргүүлэн худалдаж авах хувьцааны тооны дээд хязгаар	Төлөөлөн удирдах зөвлөлийн эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсөн нийт энгийн хувьцааны 25 хувиас хэтрэхгүй. Энэ журам нь доорх 4 дэх хэсэгт заасан Багц худалдан авалтад хамаарахгүй.
3. Хувьцааг эргүүлэн худалдан авах захиалгийн дээд үнэ	Өмнөх 30 хоногийн Хөрөнгийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн 105 (нэг зуун тав) хувиас хэтрэхгүй.
4. Багц арилжааны худалдан авах ханшийн дээд хязгаар	Нийлбэр дүнгээрээ 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хувьцааг эргүүлэн худалдаж авах багц арилжааны хэлцлийн нэгж хувьцааны ханш нь өмнөх 30 хоногийн Хөрөнгийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн 105 (нэг зуун тав) хувиас хэтрэхгүй.
5. Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаа үргэлжлэх хугацаа	2020 оны 12 сарын 24-ний өдрөөс 2021 оны 03 сарын 31-ний өдрийг дуустал.
6. Мэдээлэл түгээх	Долоо хоног тутмын баасан гарагт тухайн долоо хоногт халаасалсан хувьцааны тоо, дундаж ханшийн талаарх мэдээллийг Компанийн www.lend.mn болон Хөрөнгийн биржийн www.mse.mn цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.



“ЛэндМН ББСБ” ХК-ийн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн
ээлжит хурлын 20/37 тоот тогтоолын Хавсралт 2

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВЧ, ХАЛААСЛАХ ЖУРАМ

1. Нийтлэг Үндэслэл

1.1. Энэхүү журмаар “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн гаргасан нийт энгийн хувьцааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдан авч, халааслах ажиллагааг зохицуулна.

2. Холбогдох хууль тогтоомж

2.1. Энэхүү журам нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, ЛэндМН ББСБ ХК-ийн дүрэм, “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Монголын Хөрөнгийн биржийн Арилжааны журам”, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйлчилнэ.

2.2. Энэхүү журам нь хууль, эрх зүйн хэм хэмжээний акттай зөрчилдсөн тохиолдолд холбогдох хууль, эрх зүйн хэм хэмжээний актыг баримтална.

3. Үйлчлэх хүрээ

3.1. Энэхүү журам нь Монголын хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагдаж буй Компанийн хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаанд үйлчилнэ.

3.2. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч АНД Системс ХХК-ийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авах харилцаанд энэхүү журам хамаарахгүй.

4. Хувьцааг эргүүлэн худалдаж авах нөхцөл

4.1. Эргүүлэн худалдаж авах хувьцааны нийт хэмжээ нь Компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 5 (тав) хувиас буюу 40,000,000 (дөчин сая) ширхэг хувьцаанаас хэтрэхгүй.

4.2. Эргүүлэн худалдаж авах хувьцааны төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр гүйцэтгэнэ.

4.3. Эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг дараах хязгаарын хүрээнд явуулна:

4.3.1. Эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны дээд үнэ нь өмнөх 30 хоногийн Хөрөнгийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн 105 (нэг зуун тав) хувиас хэтрэхгүй;

4.3.2. 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий багц арилжааны хэлцлийн ханш нь өмнөх 30 хоногийн Хөрөнгийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн 105 (нэг зуун тав) хувиас хэтрэхгүй.

- 4.3.3. Нэг өдөрт эргүүлэн худалдаж авах хувьцааны тоо Төлөөлөн удирдах зөвлөлийн эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсөн нийт энгийн хувьцааны 10 (арав) хувиас хэтрэхгүй. Энэхүү журам нь дээрх 4.3.2 дахь хэсэгт заасан Багц худалдан авалтад хамаарахгүй;
- 4.3.4. Дараалсан 30 хоногийн хугацаанд эргүүлэн худалдаж авах хувьцааны тоо Төлөөлөн удирдах зөвлөлийн эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсөн нийт энгийн хувьцааны 25 (хорин тав) хувиас хэтрэхгүй. Энэхүү журам нь дээрх 4.3.2 дахь хэсэгт заасан Багц худалдан авалтад хамаарахгүй;
- 4.3.5. Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг 2020 оны 12 сарын 23-ны өдрөөс 2021 оны 3 сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэнэ.

5. Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаанд оролцогчийн бүрэн эрх

5.1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) дараах бүрэн эрхтэй:

- 5.1.1. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - 5.1.2. Энэхүү журмын дагуу эргүүлэн худалдаж авсан компанийн халаасны хувьцааг буцаан гүйлгээнд оруулах асуудлыг шийдвэрлэх;
 - 5.1.3. Хувьцааг эргүүлэн худалдаж авах асуудлаар хяналт тавих, асуулт тавих, зөвлөмж гаргах, үүрэг даалгавар өгөх, зогсоох.
- 5.2. Компанийн Гүйцэтгэх захирал нь хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой дараах бүрэн эрхтэй:
- 5.2.1. Хувьцааг эргүүлэн худалдаж авах ажиллагааг ТУЗ-өөс олгосон бүрэн эрх, энэхүү журамд заасан хүрээнд удирдан зохион байгуулах;
 - 5.2.2. Энэхүү журмын хэрэгжилт, эргүүлэн худалдаж авсан хувьцааны талаарх мэдээллийг тухай бүр ТУЗ-д тайлагнах;
 - 5.2.3. Компани нь хувьцааг эргүүлэн худалдаж авах ажиллагаанд аливаа ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх;
 - 5.2.4. Хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой аливаа гэрээ хэлцэл байгуулах;
 - 5.2.5. Хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой мэдээллийг олон нийтэд болон эрх бүхий этгээдэд мэдэгдэх, мэдээлэх, Компанийн хувьцаа эзэмшигчдэд заавар, зөвлөгөө өгөх, эргүүлэн худалдаж авсан хувьцааг Үнэт цаасны бүртгэлээс хасуулах, Үнэт цаасны бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулахтай холбоотой ажлыг тухай бүр зохион байгуулах.

6. Хүчин төгөлдөр болох хугацаа

6.1. Энэхүү журам нь батлагдсан өдрөөсөө хүчин төгөлдөр болно.

“ЛЭНДМН ББСБ” ХК

ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 23-ны өдөр

№ 20/38

Улаанбаатар хот

Дотоод хяналтын бодлого батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.6.7 дахь хэсэг, Компанийн ТУЗ-ийн 2020 оны 12 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Дотоод хяналтын бодлогыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Дотоод хяналтын бодлогыг хэрэгжүүлж ажиллах, гүйцэтгэлийг ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.
3. Дотоод хяналтын бодлого батлагдсантай холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай өөрчлөлтийн саналыг ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо (Б.Дэлгэржаргал)-д даалгасугай.

